

Маргааны товч:

Улсын бүртгэгч нь... Чингэлтэй дүүргийн 128.76 м.кв талбай бүхий оффис, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийг Д.Мөнхбатын нэр дээрээс Л.Батбаатарын нэр дээр шилжүүлэн бүртгэжээ.

Нэхэмжлэгчээс тус бүртгэлийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж, үндэслэлээ "... Улсын бүртгэгч нь прокурорын зөвшөөрөл даалгаврын дагуу шилжилт хөдөлгөөнийг хязгаарлачихсан, хориг тавьчихсан байсан үл хөдлөх хөрөнгө дээр эрх бүхий бус албан тушаалтны явуулсан бичгийг үндэслээд, урдах хориг нь цуцлагдаагүй байхад Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж, Л.Батбаатарын нэр дээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаж өгсөн, үүнээс болж миний хууль ёсны эрх ашиг зөрчигдсэн ..." гэж;

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "... Шүүхийн шийдвэрээр албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх гээд 2 тусдаа, эрх сэргээх, өмчлөх эрх шилжүүлэх гэсэн бүртгэл байгаа. 2022 оны 11 сарын 14-ний өдөр өмчлөх эрх шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэлийн журмаар шилжүүлэн бүртгэсэн бүртгэл нь ямар нэгэн хууль зөрчсөн үйлдэл байхгүй. Мэдээллийн сангаас шүүгээд үзэхэд өмчлөгч нь Д.Мөнхбат, түүний эрхийг сэргээсэн байсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгохоор заасан. Тухайн Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсээс эрх бүхий албан тушаалтны өгсөн албан бичиг, албан шийдвэрийг үндэслэн эрхийг нь сэргээсний үндсэн дээр өмчлөх эрхийг улсын бүртгэлд шилжүүлэн бүртгэсэн процесс явуулсан. Тэгэхээр энэ бүртгэл нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бүртгэл ..." гэж;

Гуравдагч этгээдээс "... Би Д.Мөнхбат гэдэг хүнд мөнгө зээлдүүлж, зээлийн болон барьцааны гэрээ байгуулсан, мөнгөний хүүг авахаар хайсан боловч олдоогүй тул шүүхэд хандсан, ... Шүүхийн шийдвэр гарсны дараа дуудлага худалдаанд оролцож, тухайн үл хөдлөх хөрөнгийг худалдан авч, төлбөрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлсэн, ... Энэ хооронд Д.Мөнхбатад залилуулсан З.Наран гэх хүн гарч ирээд миний үл хөдлөх эд хөрөнгө байсан гээд дуудлага худалдаагаар авсан уг үл хөдлөх хөрөнгийг чөлөөлж өгдөггүй, ... би тухайн үедээ хуулийн дагуу л явсан, улсын бүртгэгч хуулийн дагуу бүртгэж авсан ..." гэх агуулгаар тус тус маргасан байна.